

МОНГОЛ УЛС

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БА ЛОЖИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ
ТӨСӨЛ
P174806

[Төсөл]

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ (БОНХТ)

2021 оны 10-р сар

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Монгол Улс нь Монгол Улсын Зам, тээврийн холболт ба ложистикийг сайжруулах төсөл (P174806)-ийг Зам, тээврийн хөгжлийн яам (ЗТХЯ), Сангийн яам (СЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ)-ны оролцоотойгоор хэрэгжүүлнэ. Төслийн санхүүжилтийг Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (цаашид Банк гэх) олгоно.
2. Төслийг Байгаль орчин, нийгмийн стандарт (БОНС)-уудад нийцүүлэн хэрэгжүүлэх зорилгоор тодорхой бодит арга хэмжээ, үйл ажиллагаануудыг Монгол Улс авч хэрэгжүүлнэ. Байгаль орчин, нийгмийн хариуцлагын төлөвлөгөө (БОНХТ)-нд бодит арга хэмжээ бол үйл ажиллагаануудад, аливаа тодорхой баримт бичиг эсвэл төлөвлөгөө, түүнчлэн эдгээр үйл ажиллагаанууд тус бүрийг хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхойлсон байдаг.
3. Монгол Улс нь мөн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (БОНМХ), Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННҮ), Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ), Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ), Хөдөлмөр эрхлэлтийн менежментийн журам (ХЭМЖ) болон эдгээр байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдэд заасан цаг хугацаа зэрэг Байгаль орчин, нийгмийн хариуцлагын энэ төлөвлөгөө (БОНХТ)-нд дурдсан, Байгаль орчин, нийгмийн хүрээний хамрах хүрээнд шаардагдах байгаль орчин, нийгмийн бусад баримт бичгийн заалтуудыг дагаж мөрдөнө.
4. Монгол Улс нь тухайлсан арга хэмжээнүүд болон үйл ажиллагаануудыг Зүйл 1-т заасан яам, агентлаг, эсхүл нэгжээр гүйцэтгүүлэхдээ БОНХТ-ний бүх шаардлагуудтай нийцүүлэх үүргийг хүлээнэ.
5. Монгол Улс нь БОНХТ-д тусгасан бодит арга хэмжээнүүд болон үйл ажиллагаануудын хэрэгжилтэд БОНХТ-ний шаардлага болон хууль ёсны гэрээний нөхцөлийн дагуу хяналт тавьж, Банкинд тайлагнах ба Банк нь төслийг хэрэгжүүлэх явцад авсан бодит арга хэмжээнүүд, үйл ажиллагаануудын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, үнэлнэ.
6. Төслийн өөрчлөлтүүдийн дасан зохицох менежментийг тусгах, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал үүсэх, эсхүл БОНХТ-ний хүрээнд хийгдсэн төслийн гүйцэтгэлийн үнэлгээнд хариу өгөх зорилгоор төслийн хэрэгжилтийн явцад Банк болон Зээлдэгч хооронд тохиролцсоны дагуу БОНХТ-г цаг тухайд нь шинэчилж болно. Энэ тохиолдолд, өөрчлөлтүүдийг ЗТХЯ нь *Банктай* зөвшилцөж тохиролцсоны үндсэн дээр БОНХТ-нд тэдгээр өөрчлөлтийг тусгаж шинэчилнэ. БОНХТ-нд оруулахаар тохирсон өөрчлөлтүүдийг Банк болон Монгол Улсын хооронд гарын үсэг бүхий албан бичгээр солилцож баримтжуулна. Монгол Улс нь шинэчилсэн БОНХТ-г нэн даруй олон нийтэд ил тод мэдээлнэ.
7. Төслийн хэрэгжилтийн явцад гарсан Төслийн өөрчлөлт, урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал эсхүл төслийн гүйцэтгэл нь эрсдэл болон нөлөөлөлд хүргэх өөрчлөлтийг бий болгож байгаа тохиолдолд, хэрвээ шаардлагатай гэж үзвэл байгаль орчин, нийтийн эрүүл мэнд, зэрлэг ан амьтан, амьжиргаа, хөдөлгөөний аюулгүй байдлын нөлөөлөл, ажиллах хүчний урсгал зэрэг төсөлд хамааралтай ийм төрлийн эрсдэл болон нөлөөллийг арилгах арга хэмжээнүүд, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтийг Монгол Улс гаргана.

БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БА ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАГНАЛ			
A	Төслийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүйн ажиллагаа (БОНЭМАА)-ны гүйцэтгэлийн хяналт шинжилгээний тайланг тогтмол бэлтгэж Банкнд ирүүлэх ба уг тайланд тусгах асуудал БОНХТ-ний хэрэгжилт, БОНХТ-ний хүрээнд шаардагдах байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлын явц, талуудын оролцоог хангах үйл ажиллагаа, өргөдөл гомдол барагдуулах механизмын чиг үүрэг зэргээр хязгаарлагдахгүй.	Төслийн хэрэгжилтийн туршид зургаан сар тутамд, эхний тайланг хууль ёсны зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсон ("Хүчин төгөлдөр болох огноо")-оос хойш зургаа дахь сард ирүүлнэ.	ЗТХЯ
B	Төсөлтэй холбоотой замын барилгын ажлын явцад гарсан осол зэрэг аливаа тохиолдол, осол гэмтэл гарсан, эсхүл байгаль орчин, нөлөөлөлд өртсөн иргэд, олон нийт, ажиллагсад ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлсэн эсхүл үзүүлж болзошгүй тохиолдолд Банкнд нэн даруй мэдэгдэнэ. Тухайн тохиолдол эсхүл осол гэмтлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийн зэрэгцээ тухайн тохиолдолд авсан шуурхай арга хэмжээ, эсхүл авахаар төлөвлөж буй арга хэмжээ, мөн холбогдох гэрээлэгч, хяналт тавих байгууллагаас зохих ёсоор өгсөн бүхий л мэдээллийг ирүүлнэ. Улмаар, Банкнаас шаардсаны дагуу тухайн тохиолдол, эсхүл осол гэмтлийн талаарх тайланг бэлтгэж, үүнийг дахин давтагдахаас сэргийлэх аливаа арга хэмжээг санал болгоно.	Тохиолдол/осол гэмтлийн талаар олж мэдсэнээс хойш 48 цагийн дотор Банкнд мэдэгдэх ба Банктай өөрөөр албан бичгээр тохироогүй бол хэрэг явдал гарснаас хойш хуанлийн 7 хоногийн дотор дараагийн тайланг бэлтгэнэ.	ЗТХЯ
БОНС 1: БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ЭРСДЭЛ БА НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, УДИРДЛАГА			
1.1	ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ Байгаль орчны болон нийгмийн хөгжлийн экспертийг томилох зэрэг Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийг дэмжих чадварлаг боловсон хүчин, нөөц бүхий зохион байгуулалтын бүтцийг бий болгож бүтцийг хадгалах.	Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш хойш 30 хоногийн дотор байгаль орчин, нийгмийн ажилтныг томилох ба төсөл байгаль орчин, нийгмийн ажилтныг томилох ба төслийн нийгмийн ажилтныг тозохион байгуулалтын бүтэц, түүний дотор тухайн мэргэжилтнүүдийг хэвээр хадгалж ажиллуулна.	ЗТХЯ

БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БА ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
1.2	<p>БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮНЭЛГЭЭ</p> <p>(а) Төсөлд зориулан бэлтгэсэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг Банкинд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар шинэчлэх, нийтэд ил тод болгох, зөвлөлдөх, батлах, хэрэгжүүлэх.</p> <p>(б) Сүүлийн бээрийн холболтын зам хүртэлх биологийн олон янз байдал, соёлын өвийн үнэлгээг хамруулсан хээрийн судалгааг Банкинд зөвшөөрөгдөх Ажлын даалгаврын дагуу Байгаль орчин, нийгмийн стандарт 6 (БОНС) ба БОНС 8-ын шаардлагад нийцүүлсэн хийж байгааг баталгаажуулах.</p> <p>(в) Бүс нутгийн жишиг ложистикийн төвийн байршлыг баталгаажуулж, нарийвчилсан зураг төслийг боловсруулсны дараа ложистикийн төвийн БОНМТ-г нэгтгэсэн иж бүрэн БОННУ-г боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдсөнийг баталгаажуулах.</p> <p>(г) Бусад дэд төслүүдийн БОННУ болон БОНМТ-г төслийн Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ (БОНМХ)-нд дэд төслийн нягтлан шалгалт, үнэлгээний журмын дагуу гүйцэтгэж, нийтэд ил тод болгож зөвлөлдсөнийг, мөн бүх БОННУ-д оруулсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг БОНС-ын дагуу Банкинд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар хэрэгжүүлснийг баталгаажуулах.</p>	<p>(а) Худалдан авалттай холбоотой үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө инженерийн нарийвчилсан зураг төслийг аль болох эрт бэлэн болгоно.</p> <p>(б) Биологийн олон янз байдал, соёлын өвийн үнэлгээ зэрэг хээрийн судалгааны Ажлын даалгаврыг хээрийн судалгааны ажлыг эхлүүлэхээс өмнө Банкаар хянуулж, зөвшөөрөл авахаар ирүүлнэ.</p> <p>(в) Бүс нутгийн жишиг ложистикийн төвийн иж бүрэн БОННУ-г боловсруулж, нийтэд ил тод болгон зөвлөлдөх ба худалдан авах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө Банкаар хянуулж, зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.</p> <p>(г) БОНМХ-ний хянан шалгах, үнэлгээний журмын дагуу бусад дэд төслүүдийн БОННУ болон БОНМТ-нүүдийг боловсруулж, нийтэд ил тод болгож зөвлөлдөх ба худалдан авах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө Банкаар хянуулж, зөвшөөрөл авахаар хүргүүлнэ. БОННУ-нүүдэд тусгагдсан нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг төслийн хэрэгжилтийн туршид хэрэгжүүлнэ.</p>	ЗТХЯ

БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БА ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
1.3	<p>УДИРДЛАГЫН АРГА ХЭРЭГСЛҮҮД</p> <p>Аливаа санал болгосон дэд төслийг БОНМХ-ний дагуу магадлан шалгасны дараа шаардлагатай бол, дэд төслийн БОННУ, БОНМТ болон байгаль орчин, нийгмийн бусад төлөвлөгөөнүүдийг Банкинд хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдөж, батлуулан хэрэгжүүлэх.</p> <p>Байгаль орчин, нийгмийн эрсдэлийг нягтлан шалгах маягыг мэдээлэх, хэсэгчлэн шалгуулах зорилгоор Банкинд илгээх.</p>	<p>БОНМХ, БОННУ-нүүд, БОНМТ-нүүд болон байгаль орчин, нийгмийн бусад төлөвлөгөөнүүд нь төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид хэрэгжих ёстой бөгөөд дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн баримт бичгүүд, төлөвлөгөөнүүдийг боловсруулж, нийтэд ил тод болгон зөвлөлдөх ба дэд төсөл тус бүрийн худалдан авах үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө Банкаар хянуулж, зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.</p> <p>Холбогдох үйл ажиллагаануудын инженерийн нарийвчилсан зураг төслийг аль болох эрт бэлэн болгоно.</p>	ЗТХЯ
1.4	<p>ГҮЙЦЭТГЭГЧИЙН МЕНЕЖМЕНТ</p> <p>Байгаль орчин, нийгмийн холбогдох баримт бичиг болон эсхүл төлөвлөгөөнүүд, Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам зэрэг БОНХТ-ний холбогдох асуудлуудыг гүйцэтгэгчийн худалдан авалтын баримт бичгийн БОНЭМАА-ны шаардлагуудад оруулах, цаашид гүйцэтгэгч байгуулсан гэрээнийхээ БОНЭМАА-ны шаардлагуудад нийцүүлэн ажиллаж байгааг баталгаажуулах.</p>	<p>Байгаль орчин, нийгмийн холбогдох баримт бичгүүд болон эсхүл төлөвлөгөөнүүд зэрэг БОНХТ-ны холбогдох асуудлууд болон ХХЗЖ-д худалдан авах ажиллагаа эхлэхээс өмнө гүйцэтгэгчийн тендерийн баримт бичгийн БОНЭМАА-ны шаардлагуудад тусгана.</p> <p>ЗТХЯ нь төслийн хэрэгжилтийн туршид гүйцэтгэгч нар гэрээнийхээ БОНЭМАА-ны шаардлагуудыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.</p>	ЗТХЯ

БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БА ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
1.5	<p>ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА</p> <p>Төслийн хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээ, судалгаа (хэрэв техник эдийн засгийн үндэслэл зэрэг ажлууд байгаа бол), чадавхыг бэхжүүлэх, сургалт болон техникийн туслалцааны бусад үйл ажиллагаанууд нь Банкинд хүлээн зөвшөөрөгдсөн Ажлын даалгаврын дагуу явагдаж байгааг, Байгаль орчин, нийгмийн стандартуудын холбогдох шаардлагыг тусгасныг баталгаажуулах.</p> <p>Байгаль орчин, нийгмийн аливаа үнэлгээ, холбогдох байгаль орчин, нийгмийн хэрэгслүүд үүгээр хязгаарлагдахгүй техникийн туслалцааны үйл ажиллагаанаас гарах аливаа үр дүнг БОНС-уудтай нийцэж байгааг баталгаажуулах.</p>	Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид.	ЗТХЯ
1.6	<p>БОЛЗОШГҮЙ, ОНЦГОЙ БАЙДЛЫН ҮЕД АВАХ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ</p> <p>Болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг (БОБҮАХАБХ)-ийн гарын авлагад БОНС-уудын дагуу болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хэрэгжилтийн БОЭМАА-ны үнэлгээ, менежментийн зохицуулалтуудыг тодорхойлон оруулсныг баталгаажуулах. БОБҮАХАБХ –ын гарын авлага төслийн БОНМХ-ны нэмэлт хавсралт болно.</p> <p>БОБҮАХАБХ–ын гарын авлага болон БОНС-уудын дагуу төслийн болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хүрээнд шаардлагатай байгаль орчин, нийгмийн аливаа арга хэрэгслүүдийг боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдөж батлах, үүний дараа дурьдагдсан БОНС-уудын арга хэрэгслүүдийн хүрээнд шаардлагатай арга хэмжээнүүд, үйл ажиллагаануудыг тодорхойлсон хугацааны дотор хэрэгжүүлэх.</p> <p>БОБҮАХАБХ–ын байгаль орчин, нийгмийн хүрээнд боловсруулсан арга хэрэгслүүд нь энэ төслийн хүрээнд боловсруулсан арга хэрэгслүүдийн нэг хэсэг байна.</p>	<p>Банкинд хүлээн зөвшөөрөгдөх хэлбэр, агуулгаар БОБҮАХАБХ -ийн гарын авлагыг аль болох эрт, гэхдээ болзошгүй, онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хүрээний аливаа үйл ажиллагаа эхлэхээс өмнө батална.</p> <p>Байгаль орчин, нийгмийн тус тусын арга хэрэгслийг боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдөөд Банкаар хянуулж, зөвшөөрөл авахаар хүргүүлэх ба дараа нь байгаль орчин, нийгмийн хэрэгслүүдийг шаарддаг төслийн холбогдох үйл ажиллагаануудын худалдан авах ажиллагааг эхлүүлэхийн өмнө батлуулна. Байгаль орчин, нийгмийн хэрэгслүүдийг төслийн хэрэгжилтийн туршид тэдгээрийн нөхцөлийн дагуу хэрэгжүүлнэ.</p>	ЗТХЯ
БОНС 2: АЖИЛЛАХ ХҮЧ БА ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ			

БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮД БА ҮЙЛ АЖИЛЛАГААНУУД		ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭТГЭЭД/ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА
2.1	ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ Төслийн батлагдсан Хөдөлмөрийн харилцааг зохицуулах журам (ХХЗЖ)-ыг шаардлагатай үед шинэчлэн хэрэгжүүлэх.	ХХЗЖ-ыг төслийн хэрэгжилтийн туршид хэрэгжүүлэх ба шаардлагатай үед шинэчилнэ.	ЗТХЯ
2.2	ТӨСЛИЙН АЖИЛЧДЫН ГОМДЛЫГ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ БОНС 2-т нийцсэн, төслийн ажилчдын өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх механизмыг ХХЗЖ-д тодорхойлсны дагуу бий болгож, хадгалж, үйл ажиллагааг явуулах.	Гомдол барагдуулах механизмыг ажилчдыг төслийн ажилд авахаас өмнө ажиллуулах ба төслийн хэрэгжилтийн туршид ажиллагааг хадгалагдана.	ЗТХЯ
2.3	ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ (ХЭБЭА)-Н АРГА ХЭМЖЭЭНҮҮД Төслийг хэрэгжүүлэх явцад боловсруулах БОНМХ болон дэд төслийн БОНМТ-д заасан ХАБЭА-н арга хэмжээнүүдийг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх.	Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны туршид.	ЗТХЯ
БОНС 3: НӨӨЦИЙГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ, БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БА УДИРДЛАГА			
3.1	НӨӨЦИЙГ ҮР АШИГТАЙ АШИГЛАХ, БОХИРДЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БА УДИРДЛАГА: Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлоос урьдчилан сэргийлэх ба удирдлагын арга хэмжээг дээрх 1.3-д заасан үйл ажиллагааны хүрээнд боловсруулах БОНМТ-нд тусгах.	БОНМТ-нүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй ижил хугацаанд.	
БОНС 4: ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ			
4.1	ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ Замын хөдөлгөөн, авто замын аюулгүй байдлын эрсдлийг үнэлж, зохицуулах зорилгоор дээрх 1.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд боловсруулах БОНМТ-нд арга хэмжээнүүд, үйл ажиллагаануудыг оруулж, батлуулан хэрэгжүүлэх.	Дэд төслүүдийн БОНМТ-нүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй ижил хугацаанд.	ЗТХЯ
4.2	ИРГЭДИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ Төслийн ажилчдын зан байдал, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой эрсдэл, ложистикийн төвийг ашиглаж буй ачааны машины жолооч зэрэг төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй иргэдэд учирч болзошгүй тодорхой эрсдэл, нөлөөллийг үнэлэх, удирдах арга хэмжээнүүд болон үйл ажиллагааг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх ба эдгээр арга хэмжээг төслийн хүрээнд боловсруулах БОНМТ-нд БОНМХ-ний дагуу, Банкинд зөвшөөрөгдөх хэмжээнд оруулж тусгах.	Дэд төслүүдийн БОНМТ-нүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй ижил хугацаанд.	ЗТХЯ

4.3	<p>ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ БА ДАРАМТ</p> <p>Төслийн бүх үйл ажиллагаанд зориулсан ерөнхий БОННУ-нд Жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ) болон Бэлгийн мөлжлөг ба дарамт (БМД)-ын эрсдэлийн үнэлгээг оруулах ба Жендерт суурилсан хүчирхийллийн бие даасан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, нийтэд ил тод болгох, зөвлөлдөх, хэрэгжүүлэх.</p>	Дэд төслүүдийн БОННУ-нүүдтэй ижил хугацаанд.	ЗТХЯ
4.4	<p>ХАМГААЛАЛТЫН АЖИЛТАН</p> <p>Төслийн ажилчид, барилгын ажлын талбай, хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор хамгаалалтын ажилтнуудыг хөлслөн ажиллуулах эрсдэл зэрэг төслийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлэх. БОНС 4-ийн шаардлагад нийцсэн Аюулгүй байдлын ажилтны удирдлагын бие даасан төлөвлөгөөг Банкны хүлээсэн хэмжээнд боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх.</p>	Дэд төслүүдийн БОННУ-нүүд болон БОНМТ-нүүдтэй ижил хугацаанд.	ЗТХЯ
БОНС 5: ГАЗАР ЧӨЛӨӨЛӨЛТ, ГАЗАР АШИГЛАЛТЫН ХЯЗГААРЛАЛТ БА АЛБАДАН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТ			
5.1	<p>НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</p> <p>БОНС 5 болон төсөлд зориулж бэлтгэсэн Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ (НШБХ)-ний шаардлагад нийцсэн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (НШТ)-г боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх ба үүний дараа холбогдох үйл ажиллагаа явуулахаас өмнө болон нөлөөлөлд өртсөн хүмүүсийн биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө тус тусын НШТ-нүүдийг Банкинд хүлээн зөвшөөрөгдөх байдлаар баталж хэрэгжүүлэх.</p>	БОННУ-гээр НШТ-нүүдийг боловсруулах шаардлагатай гэж үзвэл үүнийг боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдөөд Банкинд хянуулах, зөвшөөрөл авахаар хүргүүлэх ба дараа нь газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлттэй хамааралтай үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө болон нөлөөлөлд өртсөн хүмүүсийн биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийхээс өмнө баталж хэрэгжүүлнэ.	ЗТХЯ
БОНС 6: БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ БА АМЬД БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ УДИРДЛАГА			
6.1	<p>БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ЭРСДЭЛ БА НӨЛӨӨЛӨЛ</p> <p>Дэд төслийн БОННУ/БОНМТ-нүүдийг бэлтгэх явцад биологийн олон янз байдлын эрсдэл, нөлөөллийг тодорхойлох ба дээрх 1.3-т заасан үйл ажиллагааны хүрээнд боловсруулах БОНМТ болон эсхүл Биологийн олон янз байдлын Менежментийн төлөвлөгөөний шаардлагын дагуу ийм эрсдэл/нөлөөллийг үнэлэх, зохицуулах арга хэмжээнүүд болон үйл ажиллагаануудыг баталж хэрэгжүүлэх.</p>	Дэд төслийн БОНМТ-нүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй ижил хугацаанд.	
БОНС 7: УУГУУЛ ИРГЭД/ӨМНӨД АФРИКИЙН САХАРЫН ҮЕ ДАМЖИН ОРХИГДСОН НУТГИЙН ИРГЭД, ИРГЭДИЙН БҮЛЭГ			

7.1	<p>ҮНДЭСТНИЙ ЦӨӨНХИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ</p> <p>Төслийн үйл ажиллагаанд холбогдох үндэстний цөөнх байгаа эсхүл дам байдлаар байгаа эсэхийг нягтлан шалгах. Дэд төслүүдийн БОННУ-д үндэстний цөөнх байгаа эсвэл дам байдлаар байгаа нь батлагдсан тохиолдолд Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөг БОНС 7 болон БОНМТ-ны дагуу, Банкинд хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар боловсруулж, нийтэд ил тод болгох, зөвлөлдөх, батлах, хэрэгжүүлэх. Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэстний цөөнхийн тодорхойлолт, үндэстний цөөнхтэй зөвлөлдөх үе шат, зөвлөлдөх зохистой арга хэлбэр, Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөний хяналт, шинжилгээ-үнэлгээг тусгах.</p>	<p>Төслийн холбогдох үйл ажиллагаанууд эхлэхээс өмнө үндэстний цөөнх байгаа эсхүл дам байдлаар байгаа эсэхийг нягтлан шалгах. Нягтлан шалгалтаар Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөө шаардлагатай тохиолдолд төслийн холбогдох үйл ажиллагаанууд эхлэхээс өмнө төлөвлөгөөг боловсруулж, нийтэд ил тод болгож, зөвлөлдөөд Банкинд хянуулж зөвшөөрөл авна. Зөвшөөрөл авсны дараа Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөг баталж төслийн хэрэгжилтийн туршид хэрэгжүүлнэ.</p>	ЗТХЯ
7.2	<p>ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ</p> <p>Үндэстний цөөнх байгаа нь тогтоогдсоны дараа төслийн ГБМ-ын нэг хэсэг болгож Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөний дагуу үндэстний цөөнхийн гомдол барагдуулах шаардлагатай механизмын зохицуулалтуудыг боловсруулж, баталж хэрэгжүүлэх.</p>	<p>Үндэстний цөөнхийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахаас өмнө болон хэрэгжилтийн туршид.</p>	
БОНС 8: СОЁЛЫН ӨВ			
8.1	<p>ОЛДВОР ОЛДОХ: Төсөлд зориулан боловсруулсан БОНМТ-ний нэг хэсэг болгон тодорхойлсон олдвор олох журмыг хэрэгжүүлэх. Сүүлийн бээрийн холболтын зам, ложистикийн төв барихдаа дээрх 1.2(б)-д дурдсанчлан соёлын өвийн эмзэг газруудаас зайлсхийх хэрэгтэй.</p>	<p>Дэд төслүүдэд хийгдэх БОННУ-тэй ижил хугацаанд.</p>	ЗТХЯ
БОНС 10: ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ БА МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ			
10.1	<p>ТАЛУУДЫН ОРОЛЦООГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ БЭЛТГЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ</p> <p>Төслийн оролцогч Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ТОХТ)-ний төслийг БОНС 10-д нийцүүлэн шинэчлэх, нийтэд дахин ил тод болгох, зөвлөлдөх, батлах, хэрэгжүүлэх ба үүнд оролцогч талуудыг цаг тухайд нь, хамааралтай, ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллээр хангах, тэдэнтэй арга заль, хөндлөнгийн оролцоо, албадлага, ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлгээс ангид уламжлал заншилтай нь нийцэх байдлаар зөвшилцөх арга хэмжээг багтаасан байна.</p>	<p>Төслийн үнэлгээний өмнө ТОХТ-ний төслийг боловсруулж нийтэд ил тод болгосон. Төслийн хэрэгжилтийн туршид шинэчилэх, нийтэд дахин ил тод болгох, зөвлөлдөх, батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд хийгдэнэ.</p>	ЗТХЯ

10.2	ТӨСЛИЙН САНАЛ ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ Гомдол барагдуулах механизмыг ТОХТ-нд тусгасны дагуу бий баталж хэрэгжүүлэх.	ТОХТ-тэй ижил хугацаанд.	ЗТХЯ
ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ			
CS1	<p>ТУА-ны ажилтнууд, төслийн оролцогч талууд, иргэд болон төслийн ажилтнуудад БОНХ-ны хэрэгжилтийн талаарх сургалтыг зохион байгуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийн банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ); • Төсөлд зориулан боловсруулсан БОНМХ болон дэд төслүүдэд зориулан бэлтгэсэн БОННУ/БОНМТ; • Талуудын оролцооны зураглал, талуудыг тодорхойлох, тэдний оролцоог хангах; • Онцгой байдлын үеийн бэлэн байдал ба хариу арга хэмжээ; • Сүүлийн бээрийн холболтын замын дагуу иргэдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах; • Халдварт өвчин, КОВИД 19-өөс урьдчилан сэргийлэх. 	Зээлийн гэрээ хүчин төгөлдөр болсны дараагаас эхлэн төсөл хэрэгжих хугацааны туршид.	ЗТХЯ нь Банкны дэмжлэгтэйгээр